

**БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛ ХИЙХ АЖЛЫН
ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	Шалгуур
	“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ” хийх тусгай зөвшөөрөлтэй байх
	Тухайн компаний үйл ажиллагааны танилцуулга
	Үнэлгээний ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан, материаллаг бааз, боловсон хүчний хангамж болон чадавхийг илтгэх бичиг баримтууд
	Сүүлийн 3 жилд хийсэн ижил төстэй ажил (гэрээний хувь, тайланг хавсаргах)
	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардлагатай ажлын багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл түүнийг гэрэл зургаар баталгаажуулах
	Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, ажлын төсөв. (баталгаажуулах)
Бэлтгэл ажил	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тогтоох
	Нарийвчилсан үнэлгээ хийх төлөвлөгөөг боловсруулах
	Тухайн төслөөс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийг тодорхойлох
	Дулааны цахилгаан станц барих газрын нөлөөллийн бүсэд байгаа айл өрх, ААНБ-с санал авах
Үндсэн ажил	Дулааны станц, дулаан дамжуулах шугам сүлжээг барьсанаар төсөлд шаардагдах усны хэрэглээ, ашиглалтыг нарийвчлан тооцож, түүнийг хангах гадаргын болон газрын доорх усны эх үүсвэрийн өнөөгийн төлөв байдлыг судалж, ашиглах боломжит усны нөөцөд тулгуурлан үнэлэлт, дүгнэлт өгөх, усны ашиглах боломжит нөөцийн талаар холбогдох байгууллагаар дүгнэлт гаргуулах
	Төсөлд ашиглахаар сонгосон техник технологи нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд халтай эсэхийг нарийвчлан тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт өгөх
	Дулааны станц болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэж тайланд тусгах
	Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгах
	Үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн /аюултай/ хог хаягдлын хэмжээ, эх үүсвэрийг нарийвчлан тодорхойлж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй аргаар цуглуулах, хуримтлуулах, ангилан ялгах, зайлуулах, боловсруулах, зөвлөмж, технологийн дарааллыг тодорхойлж өгөх

	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах</p> <p>Төсөл хэрэгжих эдэлбэр газарт Газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг хийлгэж, цаашид 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байхыг тайланд тусгах</p> <p>Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг Дулааны станц, дулаан дамжуулах шугам сүлжээг барих төсөл, төсөлд хийсэн БОННУ-ний тайланг төсөл хэрэгжих Багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон сум, аймгийн Засаг даргын /ИТХ/ саналыг авч тайланд хавсаргах</p>
<p>Тайлан боловсруулалтын ажил</p>	<p>Нарийвчилсан үнэлгээний тайланг захиалагчид 3% ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсэгтэй байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Нарийвчилсан үнэлгээний бичмэл тайлан /БОАЖЯамаар баталгаажуулсан байх/ 2. Үнэлгээ хийх үеийн гэрэл зургууд
<p>Ажил гүйцэтгэх төсөв</p>	<p>Хорин сая төгрөг (20 000 000)</p>

БОЛОВСРУУЛСАН:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн *Б. Цэрэнханд* Б. Цэрэнханд

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны салбарын бодлого, үнэлгээ, аудит хариуцсан мэргэжилтэн *Б. Пүрэвсүрэн* Б.Пүрэвсүрэн